

Салбарын цахим дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, төлөвлөлт, технологийн нэвтрүүлэлт хариуцсан шинжээч, Ганбаатар
Долгормаа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.2. Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбох, мэдээллийн нэгдсэн сүлжээг өргөтгөх, нэгж байгууллагын дотоод сүлжээний орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах							
1	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн системийг шинэчилнэ.	Системийн шинэчлэгдсэн модулийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/228 дугаар тушаалаар Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, хөтөлбөр, төлөвлөгөөний дүрэм журам шинэчлэгдэн батлагдсан, боловсролын салбарын мэдээллийн системүүдтэй уялдаа холбоогүй, бүтцийн хувьд ялгаатай, өөр программын хэл дээр бичигдсэнтэй холбоотойгоор салбарын систем хооронд мэдээлэл солилцоход хүндрэл учирдаг тул тус системийг шинэчлэх шаардлага үүссэн. Иймд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

			хэсэг байгуулагдан ажиллаж, системийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээг хийн хөгжүүлэх ажлын даалгаврыг эхний байдлаар боловсруулсан.		22-ны өдөр А/76 дугаар бүхий “Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын удирдлагын мэдээллийн системээр мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөлт болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ хийх статистик тайлан мэдээг системээр нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлэхээр системийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулсан.Тус ажлын даалгаврын дагуу ерөнхий үйл ажиллагааны процесс, шинэ системийн модулийн суурь судалгааг хийж, системийн цар хүрээний баримт бичгийг боловсруулсан. Тус системийн байгууллагын нэгтгэл, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр,төлөвлөгөө, сургалтын агуулга тестийн түвшинд хөгжүүлэгдэн	
--	--	--	---	--	--	--

					суурь дата мэдээллийг хөрвүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 16-с хариуцсан нэгжүүдтэй хамтарсан туршилтын тест хийхээр ажиллаж байна. Суралцагчийн модуль, ирц, дүн үнэлгээний бүртгэл, төгсөлт, боловсролын баримт бичиг зэрэг модулийг 2024 оны 12 дугаар сарын 31-нд хөгжүүлэн тестийн түвшинд ажиллуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
2	Боловсрол сургалтын байгууллагад сургуулийн удирдлагын болон сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	SMS, LMS систем нэвтрүүлсэн сургалтын байгууллагын тоо	2023 оны жилийн эцсийн сайрын байдлаар 381 сургууль SMS, LMS-ийг, 21 цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд БСМС-тэй мэдээлэл солилцож байна.	Боловсролын салбарын Мэдээлэл солилцооны системийг шинэчилж БСМС-тэй мэдээлэл солилцоно.	- БШУ-ны сайдын 2022 оны “Шаардлага батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага /LMS, SMS/”, А/370 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системд тавих шаардлага”-ыг тус тус баталсан. ТХААГ-аас тус шаардлагад нийцүүлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, LMS, SMS систем дээр Дижитал Эдү Менежмент ХХК, Гранд Ай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Ти ХХК, ЕСМ ХХК, Амжилт Дот Ком ХХК гэсэн 4, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем дээр Дижитал Эдү Менежмент ХХК, Гранд Ай Ти ХХК, Арта Софт Скүүл ХХК гэсэн 3 нийт давхардсан тоогоор 5 аж, ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулснаар дээрх системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. 2024 оны 12-р сарын байдлаар 520 сургууль SMS, LMS-ийг, 11 сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. - Боловсролын ерөнхий хуулийн 40.2.9 дэх заалт, МУЗГ-ын 2024 оны “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын яамны ТНБД-ын “Сургуулийн өмнөх	
--	--	--	--	--	---	--

					боловсролын байгууллагын хүүхдийн хоолны түүхий эдийн зардлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс татан төвлөрүүлэх системд тавих техникийн шаардлага"-ыг боловсруулан батлуулсан. Тус техникийн шаардлагад нийцсэн систем хөгжүүлэгч 6 байгууллагатай холбогдох журмын дагуу нууцын баталгаа гаргасны үндсэн дээр мэдээлэл солилцох гэрээ байгуулан, мэдээлэл солилцооны сервисийг хөгжүүлсэн. Ингэснээр Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасны дагуу боловсролын байгууллага зөвлөлөөрөө хэлэлцэн, сонголт хийсний үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нийслэлийн 305 төрийн өмчийн цэцэрлэгт нэвтрүүлэн ашиглаж байна. Хавсралт: 3 файл		
3	Багш бүрт компьютер олгох, боловсролын сургалтын байгууллагын дотоод сүлжээний орчин бүрдүүлэх, сургууль бүрт	Компьютертой болсон багш, хувиар, дотоод сүлжээгээ сайжруулах, ухаалаг анги, зурагттай болох захиалга, хувиар	2023-2024 оны хичээлийн жилд - 65% /намрын мэдээгээр/, Нийт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 1,118	Дотоод сүлжээний орчин бүрдүүлэх - 75%	МУЗГ-н 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" 91 дүгээр тогтоол, 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дугаар тогтоолоор батлагдсан ЕБС,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн

	цахим танхим байгуулах ажлыг үргэлжлүүлнэ		хичээлийн байрнаас 229 хичээлийн байранд дотоод сүлжээний орчин бүрдүүлсэн байна.		цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд “Цахим хэрэглээний зардал”, "Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалт" гэж тусгагдсан. Мөн БШУ-ны сайдын 2022 оны "Заавар батлах тухай" А/170 дугаар тушаалаар зарцуулах заавар батлагдсан. Тус яамнаас бараа, ажил үйлчилгээний техникийн тодорхойлолтыг батлан ТХААГ-т хүргүүлж тус байгууллагаас гүйцэтгэгч сонгон шалгаруулах ХАА-аг зохион байгуулж, гүйцэтгэгч нартай ерөнхий гэрээ байгуулан суурин болон зөөврийн компьютер, Таблет /iOS, андройд/, Ухаалаг самбар зэрэг боловсрол сургалтын зориулалттай тоног төхөөрөмжийг төрийн цахим дэлгүүрт байршуулсан. Багш бүрт зөөврийн компьютер олгох үйл ажиллагааг зохион байгуулж, 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр ЕБС- ын 13,017 багш зөөврийн компьютергүй байна гэсэн тооцоо гарсан. Эдгээр багшийг улсын төсвийн	10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	---	------------------------------------	---

					хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн хүрээнд зөөврийн компьютероор хангах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангасан. Өнөөдрийн байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалт буюу тендерээр 10,666, хосолсон сургалтын Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлсэн төслөөр 250, хандив тусламжаар 1,000, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,593, нийт 14,337 ширхэг зөөврийн компьютероор багш нарыг бүрэн хангаж ажилласан. Мөн утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл арга хэмжээг 24 сарын хугацаанд, цахим танхим байгуулах төсөл арга хэмжээг 48 сарын хугацаанд төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэй ерөнхий гэрээний журмаар зохион байгуулж байгаа бөгөөд 2024 оны 12-р сарын байдлаар 705 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 548 сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 252 захиалга өгч гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна.		
--	--	--	--	--	--	--	--

1.3. Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.

4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний санг баяжуулж, боловсролын салбарын төрийн цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.	Цахимаар үйлчилгээ үзүүлсэн тоо, Нэмэгдсэн үйлчилгээний тоо	2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй 5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна.	Лавлагаа тодорхойлолтын сан 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	Боловсролын яамнаас Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийг 2020 оноос нэвтрүүлсэн бөгөөд түүнээс хойш их, дээд сургууль төгсөгчдийн бакалавр, магистр, докторын зэргийн дипломын мэдээлэл, лавлагааг И-Монгол системд системээс авах боломж бүрдсэн. 11-р сараас Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн сангийн бүртгэлд ороогүй байгаа их, дээд сургууль төгсөгчид бакалавр, магистр, докторын зэргийн дипломын мэдээлэл оруулах хүсэлтээ И-Монгол системээр дамжуулан ЦАХИМ хэлбэрээр илгээж, бүртгүүлэх боломжтой болж цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн.12-р сарын байдлаар 460,752 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж, И-Монгол системийн мэдээллийн санг баяжуулсан байна. Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дээд боловсролын сургалтын байгууллага	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	---	--	--	---	---	--

				төгссөн тухай дипломын лавлагаа, боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа тухай тодорхойлолт болон ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар, ЭЕШ-н дүн оноо лавлагаа гэсэн 8 төрлийн лавлагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу E-Mongolia системээр дамжуулан олгож байна. Боловсролын сайдын 2024 оны “Боловсролын салбарын цахим шилжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/100 дугаартай тушаалын хэрэгжилтийг хангахаар Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Боловсролын их өгөгдлийн аналитик шинжилгээний хоёр хэрэглэгдэхүүний (Багшийн динамик, Элсэлт төгсөлтийн динамик) дашбоардыг боловсруулан боловсролын харьяа газар, хэлтсийн мэргэжилтнүүдээс ирүүлсэн санал, зөвлөмжид үндэслэн сайжруулалтыг хийж байна. Багшийн мэдлэг, арга зүй, ур чадварыг дээшлүүлэх зорилготой bagsh.edu.mn платформын хэвийн ажиллагааг Боловсролын		
--	--	--	--	--	--	--

					ерөнхий газар ханган ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар тус платформд 9945 хэрэглэгч, 152 хичээл, 391 хичээлийн модуль, 2210 хичээлийн агуулга, 19018 хичээлийн нийлбэр дүн, 1,509,796 хичээл үзэлт хандалттай байна. Тус системд шаардлагатай засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай төсвийн тушаалыг батлуулсан.		
5	Боловсролын салбарын энгийн болон тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлнэ.	БЯ-наас цахим хэлбэрээр олгодог болсон тусгай зөвшөөрлийн тоо.	И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7 дугаарт заасан БШУЯ-ны олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	Боловсролын яамнаас олгодог энгийн болон тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	Боловсролын яамнаас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1-7.4, 7.10-7.12, 8.20-8.23, 8.2 дугаар зүйлийн 6.2-6.5, 6.14-д заасан энгийн болон тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт ирүүлсэн аж ахуй, нэгж байгууллагын ирүүлсэн баримт бичигт холбогдох хууль журмын шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгаж, шаардлага хангасан хуулийн этгээдэд холбогдох 11 төрлийн тусгай болон 5 төрлийн энгийн зөвшөөрлийг олгож байна. МУ-ын Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын дагуу И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран ЗТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 7.1-7.4, 7.10-7.12	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, 2024 онд нэмэлтээр ЗТХ-ийн 8 дугаар бүлгийн 8.2 дугаар зүйлийн 6.3-6.4, 6.13-т заасан энгийн зөвшөөрлийг цахимуулж, зөвшөөрлийн хүсэлтийг https://license.mn системээр хүлээн авч шийдвэрлэх ажлыг эхлүүлсэн. Мөн ГТСМТ төвтэй хамтран аймаг, нийслэлийн засаг дарга нар олгодог цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрөл, Боловсролын яамнаас олгодог дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг цахимжуулж license.mn-д нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, 2025 оноос хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
1.4. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Цахим боловсролтой холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг тухай бүр тайлагнаж байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангаж, биелэлтийг цаг тухай бүр тайлагнана	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 465 дугаартай тогтоолоор батлагдсан "Боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журам"-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлэхээр боловсролын бүх шатны байгууллагын удирдлагын мэдээллийн системийн ерөнхий болон тусгай шаардлагыг боловсруулан, батлуулсан. “Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ын төсөл, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж, журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, "Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам"-ын төсөл, “Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай”	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	---	---

					Засгийн газрын тогтоолын төсөл, Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, ажлын албаны дүрэм, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр, бүл, хөдөлмөр хамнааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлах "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агууллагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төслийг судлан, холбогдох саналыг тухай бүр хүргүүлсэн.		
7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах /2.2.4.Цахимжсан боловсрол/	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.Цахимжсан боловсрол үйл ажиллагааны биелэлт	ЗГҮАХ-ийн биелэлтийг цаг тухай бүрт оруулж байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.Цахимжсан боловсрол үйл ажиллагааны биелэлтийг цаг тухай бүр тайлагнах	2.2.4.5-д заасны дагуу сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн сангийн Гига санаачилгын багтай хамтран “Боловсролын салбарын цахим хуваагдал” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд УИХ-ын ИЦББХ, ЦХИХХЯ, НҮБ, Дэлхий, Азийн хөгжлийн банк, Европын холбоо, Олон улсын цахилгаан холбооны байгууллага, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Үндэсний дата төв, Харилцаа холбооны зохицуулах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хороо, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Барилгын хөгжлийн төв зэрэг төр хувийн хэвшлийн байгууллагууд боловсролын салбарын нэгдсэн сүлжээний холболт, интернэт урсгалын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон. Олон улсын цахилгаан холбооны байгууллагын ГИГА санаачилгын хүрээнд ерөнхий боловсролын сургалтын байгууллагын интернэт хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар техникийн хэлэлцүүлэгт оролцож, цаашид хийх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Боловсролын салбарын хот хоорондын тоон урсгалын хэмжээг нэмэгдүүлэх, түрээсийн төлбөргүй ашиглуулах боломжийг судлах талаар 1а/164 тоот албан бичгийг ЦХХХЯ-д, зуд, үер, усны болон байгалийн гамшгийн эрсдэл үүссэн тохиолдолд бэлэн байдлыг хангах, иргэдийн харилцаа холбооны тасралтгүй байдлыг хангахад төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд	
--	--	--	--	--	---	--

					дэмжлэг үзүүлэх тухай 2/2211 тоот албан бичгийг Монгол Улсын Их Хурлын Инновац, Цахим Бодлогын Байнгын Хороонд хүргүүлж ажилласан. Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд нийслэлийн 167, аймгийн төвийн 137, сум болон багийн 398 сургуулийн 863 хичээлийн байр интернэтэд холбогдсон байгаа нь нийт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн байрны 77.5 хувь юм. Хавсралт: 2 файл		
8	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	Цахим боловсролтой холбоотой зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг цаг тухай бүр тайлагнасан.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсын боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх, мөн өрсөлдөх чадвар бүхий иргэнийг бэлтгэхэд чиглэсэн дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: Боловсролын сайдын 2024 оны А/115 тоот тушаалаар Гига санаачлага болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Сургуульд түшиглэсэн ОНЦМА (олон нийтийн цахим ажилтан) бэлтгэхэд Орхон, Дархан, Хэнтий, Дорнод аймгийн болон Улаанбаатар хотын	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					нийт 35 сургуулийн 70 багшийг сонгон, 5 бүлэг 27 сэдвийн сургалт явуулж, сургуулийн интернэт холболтын чанар болон үүнтэй холбоотой тоон мэдээллийг цуглуулах, ОНЦМА-аар дамжуулан тухайн орон нутгийн 1546 иргэнээс судалгаа авч, цахим ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан байна. - Боловсролын сайдын 2024 оны Боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын өгөгдлийн санг нэгтгэх, боловсруулах, дата анализын шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд нотолгоонд суурилсан мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэх А/100 дугаар тушаалын хүрээнд боловсролын салбарын өгөгдөлд суурилсан аналитик шинжилгээний “Багшийн динамик”, “элсэлт төгсөлтийн динамик” дашбоардуудыг хөгжүүлсэн. МБТБ, дээд боловсролын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, сурагчийн сурлагын амжилт, одоо ашиглагдаж байгаа сургалтын	
--	--	--	--	--	---	--

					байгууллагын нөхцөл байдал гэсэн 3 өгөгдлийн шинжилгээний судалгаа хийгдэж, дашбоард хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Боловсролын яам болон Монгол улсын их сургууль хамтран ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим сургалтын метаверс хувилбарыг хөгжүүлэхээр Боловсролын сайдын 2024 оны "Зардал батлах тухай" А/129 дугаартай тушаал батлагдсан. Энэ ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, шинэ залуу багш нарт зориулсан нээлттэй виртуал сургуулийг метаверс орчны 256x256 м2 хэмжээтэй 2 ширхэг газар дээр Багшийн хөгжлийн ордон, байгалийн болон нийгмийн ухааны хичээлүүдийг үзэж суралцах боломжтой виртуал сургуулий бүтээн байгуулалт хийгдэж байна.		
9	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг	Цахим боловсролтой холбоотой зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг цаг	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Багшийн мэдлэг, арга зүй, ур чадварыг дээшлүүлэх зорилготой цахим сургалтын bagsh.edu.mn платформын хэвийн ажиллагааг Боловсролын ерөнхий газар ханган	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

	тайлагнах		тухай тайлагнасан.	бүр	ажиллаж байна. Тус платформыг 2023 онд ерөнхий боловсролын сургуулийн газарзүй, физикийн 150 багшийн сургалтад туршин, 2024 оны 1 дүгээр сард ЕБС-ийн 1,400 багшид “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих модуль сургалт”-ыг амжилттай зохион байгуулж батламж олгосон юм. Мөн 2024 оны 4 сараас “5 дахь болон 10 дахь жилдээ багшилж буй багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг нийт 3,000 орчим багш нарт амжилттай зохион байгуулсан байна. Үүний үр дүнд Боловсролын ерөнхий газрын жил бүр зохион байгуулдаг багшийн мэргэжлийн хөгжлийн үндсэн сургалтыг цахимаар зохион байгуулах, багш ажлын байрандаа орон зай, цаг хугацаанаас үл хамааран тасралтгүй хөгжих боломж бүрдсэн. Өнөөдрийн байдлаар тус платформд мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 39, 2023-2024 оны хичээлийн жилийн модуль сургалтын 9, бусад сургалтын 2 нийт 50 модуль хичээлийн агуулга		Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	-----------	--	-----------------------	-----	---	--	--

					байршсан, багш нар ажлын байран дээрээ тогтмол ашиглаж байна. Тус платформын засвар үйлчилгээний баталгаат хугацаа 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр дуусгавар болсон тул системийн завсар үйлчилгээ, найдвартай ажиллагааг хангуулахаар Боловсролын сайдын 2024 оны "Зардал батлах тухай" А/219 дугаартай тушаалыг батлуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Боловсролын мэдээллийн технологийн төвд чиглэл хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
1.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах							
10	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны холбогдох мэдээллийг байршуулсан.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 5.3 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана” гэж заасны дагуу тус яамны нээлттэй өгөгдөл бий болгох, үйл	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. - Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын дагуу БШУЯ-ны нээлттэй мэдээллийг https://shilen.gov.mn/ цахим системийн шилэн индексийн тайлан бүртгэл хэсэгт оруулж 86% -ийн гүйцэтгэлтэй үнэлүүлсэн. https://shilen.gov.mn/index - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29, 32 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаандаа зөвлөмж, дүгнэлтийг ЦХИХХЯ-аас гаргуулах тухай зааснаар ЦХИХХЯ-аас “Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем” (isr.gov.mn)-ийг хөгжүүлсэн байна. Уг системд нэвтрэн бүртгэл үүсгэх, салбарын хэмжээнд нэвтрүүлэн ашиглаж байгаа, цаашид нэвтрүүлэхээр төлөвлөж буй системүүдэд зөвлөмж,	
--	--	--	--	--	--	--

					дүгнэлт авах эрхийг авахаар ЦХИХХЯ-ны 01/923 дугаартай албан бичигт хариу хүргүүлээд байна. - НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн хамтын ажиллагааны асуудал хариуцсан газар (UNDESA) нь Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллийг оролцуулсан “Монгол Улсын Үндэсний өгөгдлийн засаглалын тогтолцоо болон дижитал засаглал” сэдэвт Олон Улсын хурал, хэлэлцүүлэгт оролцож тулгамдаж буй асуудал болон хэрхэн сайжруулах талаар санал зөвлөлдөж оролцсон. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан	Биелэлтийн

			түвшин			хугаца	хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	-	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	БШУЯ-ны ТЗУГ-с зохион байгуулдаг Мэдээллийн цагаар зохион байгуулагддаг бүхий л сургалтад хамтрагдсан. Мөн ЦХХХЯ-наас зохион байгуулсан хиймэл оюун ухаан, цахим ур чадварын 2 сургалтад хамрагдсан. Сангийн яамны мэргэшсэн албан хаагчийн удирдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нхудалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга сургалтад 02 дугаар сарын 23-ны өдөр хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын цахим дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, төлөвлөлт, технологийн нэвтрүүлэлт хариуцсан шинжээч,
Ганбаатар Долгормаа /...../ Огноо: